



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГАА

Лагшан төв, Ерөнхий сайд Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 14 89, 26 14 90, Факс: (976-11) 31 06 42,
Цахим шуудан: info@monmarad.gov.mn,
Цахим хуудас: www.monmarad.gov.mn

2023. 06. 16 № 01/214

танай _____-ны № _____-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны бүртгэлийн мэдээ, түүний төрөл, даац, насжилтаар ангилсан мэдээлэл, бусад орны боомтын хяналтын албаны үзлэг шалгалтад хамрагдсан талаарх танилцуулга, тайлан мэдээг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар гарган хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

Хувийг Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газарт.

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ю.ӨЛЗИЙЖАРГАЛ



000000209

МОНГОЛ УЛСЫН ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН МЭДЭЭ

2023 оны 06 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Далбааны эзэн улсын эрхийн хүрээнд Монгол Улс хөлөг онгоцны нээлттэй бүртгэлийн үйл ажиллагааг 2003 онд Бүгд Найрамдах Сингапур Улсад эхлүүлсэн. Олон улсын хэм хэмжээний дагуу далайн тээврийн салбар дахь аливаа улсын эрх үүргийг эргийн улсын (coastal state), боомтын улсын (port state), далбааны эзэн улсын (flag state) эрх үүрэгт ангилдаг. Далайд гарцгүй Монгол Улс хөлөг онгоц бүртгэх үйл ажиллагааны хүрээнд далбааны эзэн улсын (flag state) эрх үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бусад орны зэвсэгт хүчин, тэнгисийн цэрэгт харьяалагддаг хөлөг онгоц, мөн загас агнуурын хөлөг онгоц бүртгэдэггүй ба гагцхүү худалдааны далайн тээврийн хөлөг онгоцнуудыг бүртгэдэг болно.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэхдээ тухайн хөлөг онгоцны эзэмшигчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хөлөг онгоцтой холбогдох мэдээллийг судалж, өмнө нь аль улсын бүртгэлд байсан тухай мэдээлэл, аяллын түүх, маршрут, хөлөг онгоцны насжилт, төрөл ангилал, хөлгийн багийн гишүүдийн бүрдэл болон шаардлагатай бусад мэдээллийг авч судлан, ангиллын болон техникийн хяналтын мэргэжлийн байгууллагуудын гэрчилгээг үндэслэн бүртгэдэг.

Түүнчлэн НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан эдийн засгийн хориг арга хэмжээний тухай тогтоолуудад тусгагдсан заалтуудыг НҮБ-ын гишүүн орны хувьд хэрэгжүүлэх үүрэг хүлээж үйл ажиллагаандаа тусган ажилладаг.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоцыг нэг удаагийн аялалд бүртгэх, түр болон байнгын бүртгэлд бүртгэх гэрчилгээ, багийн гишүүдийн мэргэжлийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх түр болон байнгын баталгаажуулалтын гэрчилгээг тус тус олгож байна.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 539,664 тоннын даац бүхий 25 орны эзэмшил бүхий 291 хөлөг онгоц идэвхтэй бүртгэлд хамрагдан Монгол Улсын төрийн далбааг мандуулан их далайд аялж байна.

Он	Идэвхтэй Х.О тоо	Шинээр бүртгэсэн х.о тоо
2020	352	162
2021	187	110
2022	256	197
2023.VI	291	112



Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй 291 хөлөг онгоцны эзэмшигчийг улсын харьяаллаар нь харуулбал:

Д/д	Улсын нэр	Хөлөг онгоцны тоо	Хувь %
1	Бүгд Найрамдах Сингапур Улс	50	17
2	Малайз Улс	44	14
3	Хонг Конг	38	12
4	Бүгд Найрамдах Индонез Улс	29	9
5	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	13	6
6	Белиз	12	4.5
7	Бүгд Найрамдах Солонгос Улс	14	5
8	Тайвань	11	4
9	Маршалын Арлуудын Улс	12	4.5
10	Филиппин (БНФУ)	6	2
11	Панам (БНПУ)	6	2
12	Самоа (Тусгаар тогтносон Самоа Улс)	8	3
13	Вьетнам (БНСВУ)	5	2
14	Сейцелийн арлуудын Бүгд Найрамдах Улс	8	3
15	Британийн Виржиний Арлууд	6	2
16	Ливери (БНЛУ)	5	1.5
17	Арабын Нэгдсэн Эмират Улс	5	1.5
18	Бусад (Канад, Фижи, Япон, Суринами, Соломон, Тайланд, Турк, Грек г.м)	19	7
	Нийт	291	100

Далайн эрэг бүхий улсын далайн боомт бүрд Боомтын хяналтын алба үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гол үүрэг нь их далайд аялж буй хөлөг онгоцны техникийн бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгах, олон улсын хууль эрх зүйн хүрээнд нийцэхүйц үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавихад оршдог. Ингэснээр далайд хүний амь нас эрсдэх, байгаль орчин бохирдуулах эрсдэл мөн хөлөг онгоц осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд бодит хувь нэмрээ оруулдаг байна.

Европ болон Атлантын далайн боомтын хяналтын алба (Paris MoU); Ази, Номхон далайн бүс нутгийн (Tokyo MoU); Латин Америкийн (Acuerdo de Viña del Mar); Карибын тэнгисийн (Caribbean MoU); Өмнөд болон Төв Африкийн (Abuja MoU); Хар тэнгисийн бүс нутгийн (Black Sea MoU); Газар дундын тэнгисийн (Mediterranean MoU); Энэтхэгийн далайн (Indian Ocean MoU); Персийн булан дахь (Riyadh MoU), АНУ-ын эргийн хамгаалалтын (The United States Coast Guard) зэрэг далайн эрэг бүхий улсуудын Боомтын хяналтын албад хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд харилцан хамтран ажилладаг бөгөөд далайн тээвэрт оролцогч улс орны харьяаллын хөлөг онгоцнуудад үзлэг шалгалт явуулж, үзлэгт хамрагдсан хөлөг онгоцны талаарх статистик мэдээг жил бүр гаргадаг байна.

Боомтын хяналтын албадын хяналт шалгалтын үйл ажиллагааг илүү практик талаас нь тодруулбал хөлөг онгоц дээр үзлэг шалгалт явуулахдаа “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай”, “Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх олон улсын журмын тухай”, “Даацын тэмдэглэгээний тухай”, “Хөлөг онгоцны багтаамжийн хэмжилтийн тухай” “Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай” зэрэг олон улсын гэрээ, конвенцод заасан тавигдах шаардлагын дагуу үзлэг шалгалт явуулдаг ба хөлөг онгоцны гэрчилгээ, бичиг баримтын бүрдэл алдаатай эсэх, аврах хэрэгсэл, тоног төхөөрөмж, техникийн хэвийн ажиллагаа, галын аюулгүй байдал шаардлага хангасан эсэх, эсхүл эзэмшигч компаниас гаргасан хөлгийн дотоод журам, заавар, зөвлөмж дутуу байх зэргээр аяллын үеийн аюулгүй байдлыг хангахад тавигддаг бүх төрлийн техникийн болон бичиг баримтын шаардлага бүрэн хангагдаагүй тохиолдол тус бүрийг зөрчилд бүртгэн боомтын үзлэг, шалгалтын нэгдсэн мэдээллийн санд оруулдаг болно.



График1: 2003-2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын төрийн далбаатай хөлөг онгоцнуудад хийсэн хяналт, шалгалтын тоо болон саатуулагдсан хөлөг онгоцны тоо.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоц ихэвчлэн Ази, Номхон далайн бүс нутагт далайн тээврийн үйл ажиллагаа явуулдаг болно. Монгол Улс 2003-2023 онд, нийт 20 жилийн хугацаанд 4300 гаруй хөлөг онгоц бүртгэсэн бол Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц энэ хугацаанд Ази, Номхон далайн бүс нутгийн “Tokyo MOU” PSC буюу Токиогийн санамж бичигт нэгдэн орсон боомтын хяналтын албанд нийт 2695 удаагийн үзлэг шалгалтад хамрагдаж, үүнээс 494 хөлөг онгоц саатуулагдсан байна. 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 57 удаагийн анхан шатны (initial), давхардсан тоогоор анхан болон давтан (initial and follow up) нийт 88 удаагийн үзлэг шалгалтад хамрагдаж 8 хөлөг онгоц техник тоног төхөөрөмжийн болон бичиг баримтын бүрдэл дутуу гэх үндэслэлээр зөрчилд бүртгэгдэн саатуулагдсан байна.




График2: 2017-2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын төрийн далбаатай хөлөг онгоцнуудад хийсэн хяналт, шалгалтын тоо болон саатуулагдсан хөлөг онгоцны тоо.

Европ болон Атлантын далайн бүс нутгийн боомтын хяналтын алба “Paris MOU” PSC буюу Парисын санамж бичигт нэгдэн орсон боомтын хяналтын албанд 2017 оноос 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 63 удаагийн үзлэг шалгалтад хамрагдаж, үүнээс 10 хөлөг онгоц саатуулагдсан байна. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 4 удаагийн үзлэг шалгалтад хамрагдаж 1 хөлөг онгоц техникийн болон бичиг баримтын бүрдэл дутуу гэх үндэслэлээр зөрчилд бүртгэгдэн саатуулагдсан тохиолдол бүртгэгдсэн байна.

**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА
ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН АЛБА**

МОНГОЛ УЛСЫН ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН ХӨЛӨГ ОНГОЦНЫ МЭДЭЭЛЭЛ
/ТӨРӨЛ, ДААЦ, НАСЖИЛТ/

2023 оны 06 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Д/Д	ХӨЛӨГ ОНГОЦНЫ ТӨРӨЛ	НИЙТ	НАСЖИЛТ (Year built)			ДААЦ (Gross tonnage)		
			>1990	1991-2010	2011 >	< 500 хүртэлх	501-5000	5001 >дээш
1	Ерөнхий ачаа тээврийн онгоц (General Cargo, Cargo vessel)	96	29	64	3	39	48	9
2	Газрын тос, химийн бодис тээвэрлэгч болон бусад төрлийн танкер хөлөг онгоц (Tanker)	40	13	25	2	16	22	2
3	Чирэгч хөлөг онгоц (Tug)	37	8	22	7	33	4	-
4	Дарвуулт хөлөг онгоц, бусад төрлийн завь (Yacht & Boat, Twin screw, Supply/Utility vessel)	30	5	11	14	29	1	-
5	Чиргүүл онгоц болон Хөвөгч кран (Barge & Floating Crane)	27	4	17	6	2	23	2
6	Олон төрөлт ачаа тээврийн хөлөг онгоц (Multipurpose vessel)	20	2	16	2	6	14	-
7	Хөргүүртэй ачаа тээврийн онгоц (Reefer Cargo)	11	8	3	-	4	7	-
8	Тээврийн хэрэгсэл тээвэрлэгч хөлөг онгоц (RoRo and Car ferry)	7	2	4	1	3	3	1
9	Элс тээвэрлэгч хөлөг онгоц (Sand Carrier)	6	-	2	4	-	3	3
10	Нурмаг ачаа тээврийн хөлөг онгоц (Bulkер)	4	-	2	2	-	-	4
11	Загас агнуурын хөлөг онгоц (SDV- буюу нэг удаагийн аялал, загас агнахгүй нөхцөлтэй) - Fishing vessel	4	1	3	-	3	1	-
12	Чингэлэг тээврийн хөлөг онгоц (Container ship)	4	-	4	-	-	1	3
13	Өрөмдлөгийн хөлөг онгоц (Dredger and MODU)	3	-	2	1	-	2	1
14	Засвар үйлчилгээний хөлөг онгоц (Engineering vessel)	2	-	-	2	1	1	-
НИЙТ		291	72	175	44	136	130	25